



СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦОО: ОНОЛ, ПРАКТИК

АНДРЮ ЭЛЛИС

Одоогоос гучин жилийн тэртээ анхны ардчилсан өөрчлөлт хийгдэж, түүнээс хойш сонгуулийн тогтолцоог хэдэнтээ өөрчилсөн боловч монголчууд сонгуульд өгсөн санал нь Улсын Их Хурал (УИХ) дахь суудлын тоонд тусгалаа олох механизмыг боловсронгуй болгох замаар сонгуулийн үйл явцыг засаж сайжруулахыг чармайж байна. Үүнд ялангуяа сонирхол татаж буй асуудал нь сонгуулийн холимог тогтолцоо юм.

Сонгуулийн чухам ямар тогтолцоотой байвал зохихыг Монголын ард түмэн өөрсдөө шийдэх учир эл тайлан холимог тогтолцоог таашаах, эс таашаахад бус харин уг тогтолцооны ямар загварууд байх боломжтой, тэдгээрээс үүсэж болох нөлөө, үр дагаврыг ерөнхийд нь болон Монгол Улсын нөхцөлийг авч үзэж тайлбарлахыг зорьсон болно.

Сонгуулийн холимог тогтолцооны онцлог нь түүний нэрээс тодорхой харагдах бөгөөд уг тогтолцоо нь хоёр буюу түүнээс дээш бүрэлдэхүүнтэй байдаг. Нэг бүрэлдэхүүн хэсэг нь мажоритар (олонх/дийлэнхийн) тогтолцоо юм. Үүнд харьцангуй олонхын тогтолцоо (ХОТ) нэн түгээмэл байхын зэрэгцээ багц санал (БС) буюу томсгосон тойрогт олон мандат бүхий тогтолцоо байж болохоос гадна хоёр шатлалт тогтолцоо (ХШТ)-г ч ашиглах нь бий. Холимог тогтолцоонд хоёр дахь бүрэлдэхүүн хэсэг нь хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХТТ) байх бөгөөд ихэнхдээ намын жагсаалтаар санал хураах хувилбарыг ашигладаг.

Сонгуулийн тогтолцоог өөрчлөх асуудлаар Монгол Улсад өдгөө өрнөж буй улс төрийн хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулахад зориулж энэхүү тайланг гаргав.

ПАРАЛЛЕЛЬ УУ ЭСХҮЛ ХОЛИМОГ ХУВЬ ТЭНЦҮҮЛСЭН ТОГТОЛЦОО ЮУ?

Сонгуулийн холимог тогтолцооны хоёр үндсэн хэлбэр байна. Параллель тогтолцооны бүрэлдэхүүнд багтах сонгуулийн хоёр тогтолцоо нь тусдаа бөгөөд харилцан хамааралгүй. Парламентын хэдэн гишүүнийг буюу хэдэн суудлыг аль тогтолцоогоор сонгох нь тодорхой тогтмол тоо байдаг.

Параллель тогтолцоогоор явагдсан сонгуулийн дүн нь нэг талаас олонх/дийлэнхийн тогтолцоогоор явагдсан сонгуулийн дүн буюу хувь тэнцүүлээгүй дүн, нөгөө талаас хувь тэнцүүлсэн тогтолцооны дүнгийн нийлбэрээр тодорхойлогдоно. Параллель тогтолцоо нь цэвэр олонх/дийлэнхийн тогтолцоотой харьцуулбал сонгогчдын санал гээгдэх буюу хувь тэнцвэргүй байдлыг багасгадаг ч хууль тогтоох байгууллагыг бүхэлд нь хувь тэнцүүлэх зарчмаар бүрдүүлдэггүй.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХХТТ) бол сонгуулийн хоёр тогтолцоог уялдуулж холбон хувь тэнцүүлэхийг зорьдог. Тодруулбал, олонх/дийлэнхийн тогтолцооны дүнг тодруулсны дараа хувь тэнцүүлэх журмаар хуваарилах суудлын тоог тогтоож, улмаар хувь тэнцүүлсэн дүн буюу нийлбэрийг нь тооцон гаргадаг. Эдгээр хоёр тогтолцоо практикт хэрхэн хэрэгждэгийг Хавсралт 1-ээс үзэж болно.

2022 оны наймдугаар сарын байдлаар параллель тогтолцоог дэлхийн 23 улс, нутаг дэвсгэрт; холимог хувь тэнцүүлсэн тогтолцоог есөн улс хэрэглэж байна. Эдгээр улс, нутаг дэвсгэрийн сонгуулийн тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-оос үзнэ үү. Дарангуйлагч, хэт жижиг, дайн, мөргөлдөөнтэй, жендерийн болон тодорхой хэсэг бүлгийн төлөөлөлд зориулж хувь тэнцүүлсэн тогтолцоог сонгосон, бүрэн гүйцэд мэдээлэл авах боломжгүй улсуудыг энэхүү жагсаалтад оруулаагүй болно. Түүнчлэн Шотландын парламентын сонгуульд ашигладаг холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны хувилбарыг мөн жишээ болгон орууллаа. Монгол Улсын Их хурал 2011 онд хуульчилж, улмаар 2012 оны УИХ-ын сонгуульд хэрэглэсэн параллель тогтолцоог дэлгэрэнгүй байдлаар харьцуулж харуулахыг мөн зорьсон.

Сонгуулийн бүх тогтолцоо практикт чухам ямар үр дүнд хөтлөх нь ихэнх тохиолдолд тогтолцоог хэрхэн хуульчилсан буюу нарийвчилсан зохицуулалтуудыг яаж шийдсэнээс

хамаардаг. Тэрхүү сонголт заримдаа ухамсартай хэлэлцүүлэг, шийдвэрээс, бусад үед үр дагаврыг нь гүйцэд ойлгож сайтар бодож тунгаалгүй, магадгүй урьд өмнөх практикийг механикаар үргэлжлүүлснээс шалтгаалах нь ч байна.

Эдгээр нарийвчлах асуудалд дараах хүчин зүйлс багтана.

- **Мажоритар болон хувь тэнцүүлсэн тогтолцоогоор хуваарилах суудлын харьцаа**

Холимог тогтолцоог сонгосон зорилго нь улс төрийн гол хүчнүүдийн оролцоог хангахад чиглэж буй бол хоёр бүрэлдэхүүн хэсгийн суудлын тоо нь төстэй байна. Жишээлэн авч үзсэн орнуудын туршлагыг харахад дээрх хоёр тогтолцоогоор хуваарилах суудлын тооны зөрүү буюу их, багын харьцаа 2:1-ээс хэтрээгүй байгааг харж болно. Параллель тогтолцоонд намын жагсаалтаас сонгох суудлын тоо ахиу байх тутам сонгуулийн нийт дүн бүхэлдээ тэр хэмжээгээр хувь тэнцүү байх талтай.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны үндсэн зарчим сонгуулийн дүнг ерөнхийд нь хувь тэнцүүлэхэд чиглэдэг. Гэхдээ намуудын авсан саналыг хувь тэнцүүлэхэд гарах дүнтэй харьцуулахад мажоритар суудал нь тооны хувьд илүү гарах тохиолдол байна. Тэдгээр илүү суудлыг нэмэгдэл суудал (overhang seats) гэж нэрлэнэ. Нэмэгдэл суудал нь парламентын суудлын тоог нэмж томосгоход нөлөөлнө. Энэ тохиолдолд нэмэгдэл суудал авсан намуудын төлөөлөл түлхүү болж хууль тогтоох байгууллагын бүтцийг авч үзэхэд сонгогчдын өгсөн саналтай хувь тэнцэх чанар нь нэмэгддэггүй. Намын жагсаалтаас сонгогдох нийт суудлын хувь буурах тутам нэмэгдэл суудлын тоо өсөх тал ажиглагдана. Жишээ нь, үндэсний хэмжээний нэг жагсаалтаас хэд хэдэн тойргийн жагсаалтад шилжихэд ийнхүү нэмэгддэг байна.

Үүнээс зайлсхийх нэг боломж байдаг нь нэмэлт суудлыг цөөн төлөөлөлтэй намуудад хуваарилж парламентын бүтцийг бүхэлд нь хувь тэнцэх байдлаар бүрэлдүүлэн тэнцвэржүүлэх механизмыг үндсэн хуульд тусгаж зохицуулах боломжтой ба Герман Улсад 2013 онд ийм арга хэмжээ авсан байдаг. Энэ арга нь мөн л хууль тогтоох байгууллагын суудлын тоог нэмэгдүүлэх бөгөөд намуудын дэмжлэг харьцангуй ялгаатай орон нутагт буюу тойргуудад тэнцвэржүүлэх механизм үйлчлээд эхэлбэл эл нэмэгдэл нэлээд хэмжээгээр ихэснэ.

Хууль тогтоох байгууллагын суудлын тоо нэмэгдэхээс зайлсхийх боломжит арга замуудын нэг нь намын жагсаалтаас хувь тэнцүүлэх зарчмаар ногдох суудлын тоог зохих хэмжээгээр цөөлөх явдал юм. Хоёр дахь арга нь Холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны нэмэгдэл мандатын тогтолцооны хувилбарыг (*Additional member system*) хэрэглэх явдал бөгөөд энэ хувилбарын талаар доор тайлбарлана. Дээр дурдсан хоёр хувилбарын алинд ч хувь тэнцүүлэх зарчмаас нэлээд хазайсан үр дүн ажиглагдах ба нэмэгдэл мандатын тогтолцоонд энэ хазайлт арай бага байх болно.

- **Хувь тэнцүүлэх тогтолцооны тойргуудын хэмжээ, түвшин**

Намын жагсаалтаас хувь тэнцүүлэх тогтолцоог нийт үндэсний хэмжээний нэг тойрогт эсхүл засаг захиргаа, бусад холбогдох нэгжид үндэслэн байгуулсан орон нутгийн тойргуудын түвшинд хэрэглэж болно. Сүүлийнхийг сонгосон нөхцөлд жагсаалтаас сонгогдсон гишүүд нь орон нутгаа төлөөлөх буюу тухайн орон нутгийн засаглалын бүтэцтэй ажил хэргийн бодит холбоо харилцаа тогтоох боломж бүрдэнэ.

Харьцуулан авч үзэж байгаа улсуудын хувьд Герман, Итали, Япон гэх мэт томоохон парламенттай улсуудад орон нутгийн тойргуудад намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо байдаг. Орон нутгийн тойрогт намын жагсаалтаас сонгогдох суудлын дундаж тоо нь тойрог тус бүрд байх улс төрийн намуудын төлөөллийг хангахуйц (Италид 6, Германд 19, Японд 16) түвшинд байдаг. Цөөн суудал бүхий харьцангуй жижиг парламенттай улсуудад орон нутгийн тойргуудад суудал хуваарилах байдлаар улс төрийн олон намын төлөөллийг хангах бололцоо үгүй аж.

- **Хувь тэнцүүлэх зарчмаар жагсаалтаас сонгогдох шалгуур**

Хувь тэнцүүлэх тогтолцооны зорилго нь янз бүрийн улс төрийн үзэл санаа, бодлого, байр суурийг дэмжигч улс төрийн бүлэг хэсгүүдийн оролцоог хувь тэнцүү зарчмаар хангахад чиглэдэг. Үүнтэй холбоотой зөвхөн намууд (харьцуулан авч үзэж буй улсуудад байгаа шиг) намын жагсаалтаар сонгуульд оролцон хувь тэнцүүлэх зарчмаар суудал авах боломжтойгоор зохицуулах нь энгийн үзэгдэл юм. Жагсаалтаар санал хурааж хувь тэнцүүлэх зарчмаар суудал хуваарилахад бие даагчдыг оролцуулах

нь техникийн талаасаа боломжтой боловч улс төрийн намуудаар хязгаарлах нь илүү хялбар байна.

- **Саналын хуудасны тоо**

Параллель болон холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны аль аль нь сонгуулийн хоёр системээс бүрэлдэх тул сонгогч нэр дэвшигчид болон жагсаалтад нэжгээд санал өгөх шаардлага үүснэ. Чингэхэд хоёр тусдаа саналын хуудас бөглөх эсхүл нэг хуудсанд саналаа дараалан бөглөхөөр байж болно (сүүлийн тохиолдолд нь сонгогч саналын хуудсанд хоёр санал өгч байгаа тул саналын хоёр хуудас бөглөсөн гэж тооцож болно). Түгээмэл биш боловч сонгогч нэг саналын хуудсаар нэр дэвшигч(нар)-д өгсөн саналыг тухайн нэр дэвшигчийн намд өгсөн санал гэж автоматаар давхар тооцох нь бас бий.

- **Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцооны суудал хуваарилах арга**

Намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцооны суудал хуваарилах үндсэн хоёр хувилбар байдаг. Үүнд:

- Хамгийн их үлдэгдэл (ХИҮ)-ийн зарчим буюу нэг суудалд ногдох саналын квотыг тооцсоны үндсэн дээр нэг буюу түүнээс олон квот хангасан намуудад ногдох суудлыг хуваарилсны дараа үлдсэн суудлыг квотод хамгийн их дөхсөн намуудад олгоно. Нийт хүчинтэй саналын тоог парламентын суудлын тоонд хуваах Hare-гийн квотыг үүнд хамгийн өргөн ашигладаг ба жишээ болгон авч үзэж буй улсуудад Германаас бусад нь энгийн хэлбэрийг хэрэглэдэг байна.

Германд Hare-гийн квотын илүү төвөгтэй хэлбэрийг ашигладаг. Тодруулбал, үлдэгдлийг тоолохдоо Hare-гийн квотын хагасыг давсан саналуудыг бүхэлдэн нэмж, Hare-гийн квотын хагаст хүрээгүй саналуудыг бүхэлдэн хасдаг. Чингэснээр ихэнх тохиолдолд Hare-гийн квотыг энгийн хэлбэрээр нь хэрэглэсэнтэй ижил үр дүн гардаг ч зарим тохиолдолд хуваарилсан суудлын тоо нь нийт суудлын тоонд хүрэхгүй үе байна. Энэ нөхцөлд хоёр тоог тохируулахын тулд квотыг өөрчилдөг.

- Хамгийн их дундаж (ХИД)-ийн зарчмыг ашиглах нөхцөлд тодорхой шатанд хамгийн олон санал авсан

намд суудал хуваарилдаг. Тухайн намын суудлын тоо нь урьдчилан тогтоосон хүчин зүйлүүдэд хуваагдах замаар багасдаг. Нийтлэг тохиолддог хоёр хуваагчийг дурдахад Японд хэрэглэдэг *d'Hondt*, 1, 2, 3..., Шинэ Зеландад хэрэглэдэг *Sainte-Lague*, 1, 3, 5..., байна.

Практикт *Hare* ХИД, *d'Hondt* ХИД болон *Sainte-Lague* ХИД хэрхэн ажилладагийг Хавсралт 1-ийн жишээнээс үзнэ үү.

Мөн чанарын хувьд *d'Hondt* ХИД том намуудад *Sainte-Lague* ХИД-аас илүү таатай бол жижиг намуудад *Hare* ХИД нь *Sainte-Lague* ХИД-аас тохиромжтой байх үе бас байдаг.

Дээрх шийдлүүдээс үүдэх үр дүн нь тухайн улс орны нөхцөл байдлаас ихээхэн шалтгаалдаг. Ихэнх тохиолдолд ялгаа нь тодорхой бөгөөд харьцангуй бага байх боловч зарим тохиолдолд тийм биш үе тохиолдоно. Үүний тод жишээ нь Тунист харагдсан. 2011 онд цэвэр хувьд тэнцүүлэх тогтолцоо сонгож намын жагсаалтаар санал хураан суудал хуваарилахад нийт хүчинтэй саналын 37 хувийг авсан хамгийн том намд ХИД *Hare*-гаар нийт суудлын 41 хувь ногдож, парламент дахь бусад намтай зөвшилцөхөд хүрсэн. Хэрэв *Sainte-Lague* ХИД-аар суудал хуваарилсан бол дээрх намд нийт суудлын 55 хувь ногдож засгийн газрыг дангаараа бүрдүүлэх, *d'Hondt* ХИД-аар нийт суудлын 69 хувь ногдох байв. Ингэснээр Засгийн газрыг дангаараа бүрдүүлээд зогсохгүй, дангаараа үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах боломж нээгдэх байжээ.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд суудал хуваарилахад ХИД-ийн зарчмыг ашиглах нь парламентын суудлын тоог тогтмол байлгах сайн талтай тул улс төрийн хувьд хүсмээр төдийгүй, үндсэн хуультай нийцэх талаасаа ч давуу байж болох юм. Нэмэлт гишүүний систем гэгддэг энэхүү холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны хувилбарыг Шотландын парламентыг бүрдүүлэхэд хэрэглэдэг. Мажоритар суудлыг тоолсны дараа нам тус бүрийн парламентад эзлэх мажоритар суудлын тоонд үндэслэх хуваагч ашиглан ХИД-ийн зарчимд үндэслэн намын жагсаалтаас сонгогдох суудлыг хуваарилна. Жишээ нь, намын жагсаалтын суудал хуваарилахын өмнө нэг мажоритар суудал авсан намын саналыг *d'Hondt* ХИД-ийн зарчмын дагуу хоёрт, *Sainte Lague* ХИД-аар гуравт хуваана. Түүнчлэн хоёр мажоритар суудал авсан намын саналыг *d'Hondt* ХИД-ийн зарчимд үндэслэн гуравт, *Sainte*

Lague ХИД-аар тавд гэхчлэн хуваах бөгөөд энэ зарчмыг хэрэглэснээр нэмэгдэл суудлын асуудал үүсэхгүй.

- [Хувь тэнцүүлсэн тогтолцоонд намын нээлттэй болон хаалттай жагсаалтаар санал хураах сонголт](#)

Хувь тэнцүүлсэн тогтолцоонд хаалттай жагсаалтаар санал хураах бол хэнийг, ямар дарааллаар оруулахыг нам шийдвэрлэх ба үүнд жендерийн төлөөллийг хангах гэх мэт хуульд заасан шаардлагад нийцүүлнэ. Нээлттэй жагсаалтаар санал хурааж буй нөхцөлд сонгогч нэр дэвшигчийг сонгож санал өгнө.

Намын хаалттай жагсаалтаар санал хураах нөхцөлд нэр дэвшигчдээ хэрхэн жагсаах нь намын байгууллагын эрх мэдлийн асуудал болох бөгөөд нэр дэвшүүлэхэд жендер болон цөөнхийн төлөөллийг хангах хуулийн шаардлага тавигдаж болох юм. Нэр дэвшүүлэх үйл явцыг улс төрийн намын тухай хуульд дотоод ардчилал, намын гишүүний талаар болон намын жагсаалтын эхний байруудыг мөнгөөр цохиж авахад хяналт тавих заалт оруулах зэргээр журамлаж болно.

Намын нээлттэй жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоо нь аль нэг намын төдийгүй, тухайн намын санал болгосон тодорхой нэр дэвшигчийн талаар сонголт хийх боломжийг сонгогчдод олгодог. Сонгогчдоос хангалттай дэмжлэг хүлээсэн нэр дэвшигчийн намын жагсаалтад эзлэх байр дээшилнэ. Нидерланд Улсад *Hare* квот ХИД-ийн 25 хувийг, Чех Улсад намын нэр дэвшигчид нийт сонгогчоос өгсөн саналын таван хувийг шалгуур үзүүлэлт болгодог байна. Энэхүү шалгуурыг хэт өндөр тогтоовол нээлттэй жагсаалтын сонгуулийн үр дүнд үзүүлэх нөлөө багасах ба бодит бус мэт харагдах талтай. Түүнчлэн нээлттэй жагсаалтын зохицуулалт нь нэр дэвшүүлэх үйл явцад жендер болон цөөнхийн төлөөллийн оролцоог хангахад ямар үр дагавар гаргаж болохыг давхар бодолцох нь зүйтэй.

- [Парламентад суудал хуваарилахад оролцох саналын босго](#)

Холимог системийн хэлбэрүүдийг хэрэглэдэг олон орон улс төрийн намыг хагалж хуваахгүйн тулд хууль тогтоох байгууллагад төлөөлөлтэй болох намд албан ёсны босго буюу авбал зохих саналын доод хувийг тогтоодог. Тэрхүү босгыг давсан намд намын жагсаалтаас нэр дэвшигчид

нь суудал эзлэх нөхцөл бүрддэг. Харьцуулсан судалгаанд хамрагдсан Герман, Кыргызстан, Литва, Шинэ Зеланд улсуудад саналын босго нийт хүчинтэй саналын таван хувь байгаа нь хамгийн түгээмэл хувилбар ба Итали, Япон улсуудад байх гурван хувийн босгыг мөн хүлээн зөвшөөрөх хандлага тогтсон байдаг. Эвслийн намуудад илүү өндөр босго (Итали) тавих, мажоритар суудал цөөн авсан нам босгыг автоматаар давах (Герман болон Шинэ Зеланд) зэрэг нэмэлт зохицуулалт байж болно.

Албан ёсны босго байдаг эсэхээс үл хамаарч намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоотой бүх улсад “нуугдмал” босго байдгийг дурдах нь зүйтэй. Энэ нь тойргийн цар хүрээнээс хамаардаг. Жишээ нь, намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоонд ХИҮ-ийн зарчмаар суудал эзлэхийн тулд намд сонгуулийн нэг квот байх ёстой. *Nare*-гийн ХИҮ-ийн зарчмыг хэрэглэсэн тохиолдолд тойрог 10 мандаттай бол квот нь 10, таван мандаттай бол 20, дөрвөн мандаттай бол 25 хувь байх болно. Энэхүү босгыг даваагүй нам зөвхөн үлдэгдэл дээр буух ба нэг суудал авч болох ч үлдэгдэл нь ямар байгаагаас шалтгаална.

Албан ёсны босго улс төрийн ямар үр дагавартай байж болохыг Германы туршлагаас харж болно. Сонгуулийн өмнөх кампанит ажлын явцад жижиг нам босгыг давах нь эргэлзээтэй бол ирээдүйд эвслийн засгийн газраа байгуулж болзошгүй гэж үзсэн том нам өнөөх жижиг намыг босго давуулж парламентад суудал эзлүүлэхийн тулд түүнд санал өгүүлэхээр дэмжигчдийнхээ зарим хэсгийг уриалж болно.

- **Гадаадад санал өгөх**

Гадаадад санал авах/өгөх нь өнгөн дээрээ холимог сонгуулийн тогтолцоотой хамааралгүй, тусдаа асуудал мэт боловч санал хураах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхэд зохион байгуулалт талаас бэрхшээл үүсэх магадлал байх тул хамаатай асуудал мөн. Харьцуулсан судалгаанд хамрагдсан, төрийн захиргааны хүчин чадлын хувьд хязгаарлагдмал зарим улс (Нерал) гадаадад санал хураадаггүй бол зөвхөн дипломат ажилтнууд, тэдний гэр бүл, ажиллагсдаар (Лесото) санал хураалтыг хязгаарладаг. Гэхдээ харьцуулан судалсан бусад улсын хувьд сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгүүлсэн хүмүүс гадаадаас санал өгөхийг зөвшөөрдөг байна.

Гадаадаас санал өгөх ажиллагааг зохион байгуулалтын талаас нь хялбар байлгахын тулд зөвхөн намын жагсаалтад санал өгөх байдлаар хязгаарлах эсэхийг эхлээд шийдвэрлэх шаардлагатай. Хувь тэнцүүлсэн тогтолцоонд улс нь нэг тойрог болох тохиолдолд гадаадад суугаа сонгогч Киргиз улсын жишээгээр нэг л саналын хуудас хүлээж авна. Японд гадаадад байгаа сонгогчид мажоритар суудлын төлөө өрсөлдөж буй нэр дэвшигчид санал өгөх саналын хуудас өгөөгүйг Дээд Шүүх нь хууль бус гэж үзсэн.

Гадаадад оршин суугаа сонгогчид холимог системийн хоёр бүрэлдэхүүний аль алинд нь санал өгөх боломжоор хангаж сонгуульд оролцуулах нь улам бүр нийтлэг болж байна. Энэ тохиолдолд сонгогчийг аль нэг мажоритар тойрогт хуваарилах шаардлага үүснэ. Итали хувь тэнцүүлэх зарчмын дагуу намын жагсаалтаар санал хураах сонгуулийн дөрвөн тойрог гадаадад байгуулах замаар эл асуудлыг шийддэг. Бусад улс (Герман, Япон, Шинэ Зеланд) гадаадад оршин суугаа сонгогчийг эх орондоо байхдаа хамгийн сүүлд бүртгэгдсэн тойргийнх нь саналын хуудсаар санал өгүүлэх эсхүл тухайн улсын парламентын ордон байрладаг тойрогт (Литва) санал өгүүлдэг жишээ байна.

Эдгээрийн алийг ч сонгосон сонгуулийн зохих тойргийн саналын хуудсыг тухайн сонгогчид алдаа мадаггүй илгээх, саналын хуудсыг нь холбогдох журмын дагуу тээвэрлэж тооллогод хамруулахад шаардлагатай зохион байгуулалтын болон санхүүгийн нөөцийг бүрдүүлсэн байх нь чухал. Дипломат төлөөлөгчийн газруудад санал авах байр ажиллуулах, шуудангаар болон цахимаар санал илгээх боломжууд бий. Гэхдээ тэдгээр нь сургалт, дэд бүтэц, байр сав, сонгогчийн боловсрол, ялангуяа шуудангаар санал өгөхөд сонгуулийн цаглабарт заасан цаг хугацааг баримтлах зэрэг асуудал үүсгэдэг.

МОНГОЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсад эдүгээ хэлэлцэгдэж буй сонгуулийн тогтолцооны хувилбарууд нь чухам ямар үр дагавартай байж болохыг авч үзэхдээ өнгөрсөн сонгуулиудын саналын бодит дүнд үндэслэн яригдсан хувилбарууд, арга замуудыг судалбал гарч болох үр дүнг тооцоолох боломжтой. Үүнд 2016 болон 2020 онд явагдсан УИХ-ын сонгуулийн мэдээлэл хангалттай.

Энэ арга зүйд зарим хязгаарлагдмал тал байгааг анхаарах нь зүйтэй. Тухайлбал, өөр системээр сонгууль явуулсан нөхцөлд сонгогчдын өгсөн саналын дүн ямар гарах байсныг харуулж болох ч тухайн системд сонгогчид, намууд, нэр дэвшигчдийн сэтгэл зүйд ямар сэдэл, динамик хүчин зүйл нөлөөлснөөр, чухам ямар дүн гарах байсныг тааварлах боломжгүй. Тэрчлэн олонх/дийлэнхийн тогтолцоонд суудал хуваарилалт хэрхэн явагдах, ямар хувилбар үүсэх байсныг хийсвэрээр төсөөлөх шаардлага үүснэ. Гэвч уг арга зүй нь Монголын нөхцөлд сонгуулийн тогтолцооны тодорхой хувилбар ямар үр дүнд хүргэж болох, уг нөлөөний цар хүрээ, үүнд олон хувилбартай тоо, утгыг авч үзэхэд парламент дахь төлөөлөлд ямар өөрчлөлт тусаж болохыг үнэлэх боломж олгох юм.

2016, 2020 оны УИХ-ын сонгуулийн дүнд үндэслэсэн загварчлалыг Хавсралт 2-оос үзнэ үү. Хавсралт 2-т сонгууль тус бүрийн дүн, загварчлал(ууд)-ыг, мөн 2020 оны сонгуулийн хувьд хамгийн их дундаж (ХИД суудал 2020) хэрхэн үйлчилж болохоор байгааг дэлгэрэнгүй үзүүлсэн хуудсууд бий. Нэмж дурдахад 2020 оны сонгуульд үндэслэн ХИД механизм хэрхэн ажилладгийг Хавсралт 2-т дэлгэрэнгүй үзүүлсэн нэмэлт хуудсыг мөн хавсаргав (ХИД суудал 2020). Эцэст нь Хавсралт 2-т 2016 оны УИХ-ын сонгуулийн дүнд үндэслэн параллель болон холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны загварчилсан дүн, мөн тогтолцооны тодорхой хувилбарыг дангаар нь болон нийлмэл байдлаар ашиглахад гарах үр дүнг харуулах зорилгоор 2020 оны УИХ-ын сонгуулийн дүнг 16 өөр хувилбараар үзүүллээ (Загварчлалуудын хураангуй тойм). Тогтолцооны хувилбаруудын өөр нийлбэр ашиглан загварчилсан дүнг өөрөөр гаргах боломж мэдээж бий. Олонх/дийлэнхийг бүрэлдэхүүний хувьд 2012 оны УИХ-ын сонгуулийн тогтолцооны загварын бүх хувилбарт хэрэглэсэн болно.

Үндсэн бүтцийн хувьд олонхын 47 мандат (нийт суудлын 62 хувь) бүхий 2020 оны УИХ-ын сонгуулийн 29 тойргийг ашигласан ба гурван мандаттай байсан 18 тойрогт Багц саналын тогтолцоогоор хоёр мандат ногдохоор, хоёр мандаттай 11 тойрогт харьцангуй олонхын зарчмаар нэг мандат ногдохоор тооцон нийт мандатын харьцааг 47/29 байхаар бодов. Үүнд, хувь тэнцүүлэх зарчмаар намын жагсаалтаас сонгох 29 суудлын хувьд улсаараа нэг том тойрог байх хувилбар болон улсын хэмжээнд дөрвөн том тойрог байх хувилбаруудыг ашиглалаа. Парламентын нийт суудлын 29 олонх/дийлэнхийн тогтолцоогоор, 47-г хувь

тэнцүүлсэн зарчмаар (29/47) сонгох мөн 38/38 буюу тэгш хуваахад гарах үр дүнг мөн судалж үзсэн болно.

Холимог тогтолцооны үр дүн

- 2016 болон 2020 оны УИХ-ын сонгуулийн тогтолцоонд намын жагсаалтаар санал хураах бүрэлдэхүүн нэмснээр хүлээгдэх үр дүн нь нэлээд хувь тэнцэх шинж агуулж ирж байна. Үүнд, холимог тогтолцооноос гарах үр дүн нь параллель тогтолцоотой харьцуулахад хувь тэнцэх байдал илүүтэй харагдав. Гэсэн ч үр дүнгийн хувьд хувь тэнцэх нөлөө нь давамгай гэгддэг холимог тогтолцоо ч бүрэн хэмжээгээр хувь тэнцсэн үр дүнд хүрэхгүй байгааг харж болох ба үүнд 2020 онд нийт саналын 12 хувь, 2016 онд нийт саналын 14 хувийг бие даан нэр дэвшигчид авсан нь нөлөөлж байна.
- 2020 онд багц саналын тогтолцоонд үнэмлэхүй олонхын дэмжлэг хүлээсэн намаас нэр дэвшигчдэд нийт саналын 51 хувь ногдсон бөгөөд нийт суудлын 82 хувийг авсан. Холимог системийг улсын хэмжээнд нэг тойрогтой намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцоогоор загварчилж үзэхэд *Hare* ХИҮ (2012 онд Монголд хэрэглэсэн намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцооны механизм) хамгийн олон санал авсан намд параллель системээр 72 суудал (47/29) буюу 67 хувь болон буурч, 29/47 гэж хуваагдах байсан холимог хувь тэнцүүлсэн бүтцээр намын нэр дэвшигчдэд өгсөн саналын харьцааны дагуу намд нийт саналын 51 хувь ногдох байв. Параллель системийн дэлгэрэнгүй хувилбарыг Хавсралт 2-ын 1, 2, 3 дахь загвараас, холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны хувилбарыг 6, 7 дахь загвараас харж болно.

Олонх/дийлэнхийн болон хувь тэнцүүлсэн зарчмаар хуваарилах суудлын харьцаа

- Параллель системд мажоритар болон хувь тэнцүүлсэн суудлуудын харьцааг янз бүрийн утгаар тооцож үзэхэд намуудын авах боломжтой суудлын тоо өөр өөр гарах нь ойлгомжтой. Хувь тэнцүүлсэн зарчмаар хуваарилах суудлын тоо нэмэгдэхийн хэрээр сонгуулийн үр дүнгийн хувь тэнцэх шинж нэмэгдэх ба ялангуяа жижиг намуудын төлөөлөл нэмэгдэх нөлөө үзүүлдэг.
- Ямар ч холимог системд мажоритар суудлын тоо буурахад нэр дэвшигч тухайн суудалд хүрэхийн тулд

авах ёстой саналын тоо эрс нэмэгдэнэ. Энэ хамаарлын үр нөлөө нь мажоритар бүрэлдэхүүнийг хэрхэн нарийвчлан зохицуулахаас шалтгаалах боловч бие даан нэр дэвшигчдийн хувьд мажоритар суудалд хүрэх нь улам бүр бэрхшээлтэй болно. Түүнчлэн ердийн практикт улс төрийн намууд л хувь тэнцүүлсэн тогтолцоогоор өрсөлддөг. Монгол Улсын хувьд угаасаа бие даагчид өрсөлдөхөд бэрхшээлтэй систем (2020 онд нэг л бие даагч ялалт байгуулсан)-тэй бөгөөд энэ нь байдал бүр хурцадна гэсэн үг юм. Энэ нөлөөг Хавсралт 2-ын 1, 2, 3 дахь загвараас үзэж болно.

Улсын буюу орон нутгийн хувь тэнцүүлсэн тойргууд

- Монгол Улс нь засаг захиргааны нэгжийн хувьд эхлээд аймгуудад хуваагддаг. Бүгд биш гэхэд ихэнх аймагт нэг мандат ногдох учир орон нутгийн тойрог байгуулж параллель систем ашиглан намын жагсаалтаар санал хураах боломж дутмаг байна. Ердөө ганц мандаттай нөхцөлд ялсан нэр дэвшигч сонгогдохын тулд үр дүнг хувь тэнцүүлэх боломжгүй.

Хэдий тийм боловч аймгуудыг нэгтгэх замаар орон нутагт том тойргууд байгуулж болох талтай. 2020 оны УИХ-ын сонгуулийн саналын тоонд үндэслэсэн загварчлалаас нийслэл Улаанбаатар хотыг нэг, нийт аймгийг гурван тойрог болгосон жишээг харж болно. Хавсралт 2-т параллель системийг 12, 13, 14 дэх загварт,



Сонгуулийн тойргууд байгуулах аппликэшн ашиглан гаргасан орон нутгийн дөрвөн тойрог (era.idea.int)

холимог хувь тэнцүүлсэн тогтолцоог 15, 16 дахь загварт нарийвчлан харуулав.

Энд жишээ болгон үзүүлсэн дөрвөн тойрог, тэрчлэн томсгосон тойргийн өөр ямар ч хувилбар загвар нь одоогийн засаг захиргааны болоод бусад уламжлал болж тогтсон бүтэц зохион байгуулалтад үндэслээгүй байх тул илэрхий сул тал болох нь тодорхой. Гэхдээ 2001 онд санаачилж байсан бүсчилсэн таван тойрог шиг засаг захиргааны хуваарилалттай холбоотой ирээдүйд гарч болох саналд үндэслэн загварчлал хийх боломж бий.

Хувь тэнцүүлсэн тогтолцоонд санал хураалтын дүнг тооцох механизм

- ХИҮ болон ХИД механизмын ялгаа нь загварчилсан үр дүнгээс тодорхой харагдаж буй боловч зөрүү нь харьцангуй бага байна. *D'Hondt* ХИД хамгийн том намд мэдэгдэхүйц ашигтай, *Hare* ХИҮ нь жижиг намуудын төлөөллийг оролцуулахад аль ч ХИД-аас илүү үр нөлөөтэй. Улсын хэмжээний нэг том тойргийг орон нутагт дөрвөн тойргоор солиод ХИД-ийн механизмыг хэрэглэхэд жижиг намуудын төлөөлөл цөөрдөг *Hare* ХИҮ хэрэглэхэд үүний адил цөөрдөггүй. Хавсралт 2-т үзүүлсэн загваруудын 1, 4, 5-д параллель тогтолцооны үр дүнг; 6, 7, 8, 9-д холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны үр дүнг тус тус нарийвчлан үзүүлэв.
- Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд тэнцвэржүүлэх механизмын нөлөөгөөр хагас саналын илүү суудал хүчтэй намыг дагалдах шинжтэй. Улсын хэмжээнд намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн нэг тойрогт *Hare* ХИҮ системийг хэрэглэхэд хамгийн том нам илүү хоёр суудал авна. Тэнцвэржүүлэх механизм хэрэглэсэн нөхцөлд нэмж хоёр суудал аваад парламентын суудлын тоог таван хувиар нэмэх нөлөө үзүүлнэ. Орон нутгийн дөрвөн тойрогтой тохиолдолд бүрэн хэмжээгээр хувь тэнцүүлэхэд 16 суудал буюу хууль тогтоох байгууллагыг 21 хувиар өргөжүүлэх болно. Холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны үр дүнг Хавсралт 2-ын 8, 9 дэх загварыг 15, 16 дахь загвартай харьцуулан дэлгэрүүлж үзнэ үү.
- Улсаараа нэг тойрог болох нөхцөлд холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд *Sainte-Lague* ХИД 8, 9 дэх загварт хэрэглэхэд хамгийн том нам хоёр илүү суудал авах боловч *d'Hondt* хэрэглэхэд нэг илүү суудал авна. Хавсралт

2-ын холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны 8, 9 дэх загвараас илүү дэлгэрэнгүйг үзнэ үү.

- Нэмэлт гишүүнтэй систем хэрэглэсэн холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо бол уг тогтолцооны 76 гишүүн сонгох ганц хувилбар бөгөөд гарах дүн нь холимог хувь тэнцүүлсэн тогтолцооны бусад хувилбартай харьцуулахад хувь тэнцүүлэх тал нь арай бага байх болно.

Намын нээлттэй ба хаалттай жагсаалт

Намын нээлттэй ба хаалттай жагсаалтаар санал хураах асуудлыг бүрэн тайлбарлавал энэхүү тайлангийн хамрах хүрээнээс халина. Хэдий тийм боловч 2020 оны УИХ-ын сонгуулийн дүнд үндэслэн олон мандаттай тойргуудад сонгогчид намуудад саналаа хувааж өгсөн эсэхийг тоймлон харах боломжтой. Хоёр эсхүл гурван мандаттай тойрогт нэг ижил намын нэр дэвшигчдийн авсан хамгийн их, бага саналыг шууд харьцуулан харж болно.

Ингэж харьцуулахад сонгуульд өрсөлдсөн хоёр том намын хамгийн цөөн санал авсан нэр дэвшигч нь өөрийн намаас хамгийн олон санал авсан нэр дэвшигчийн саналын дунджаар 70 хувь, жижиг намуудын хувьд энэ тоо 40 хүрэхгүй хувьтай байна. Сонгогч мандатын тоогоор санал өгөхдөө өөр өөр намыг сонгох эрмэлзэл Улаанбаатарт нэлээд илүү бөгөөд жижиг намууд Улаанбаатарт илүү санал авдаг нь харагдаж байна. Гэхдээ Улаанбаатарт ажиглагдаж буй энэхүү нөлөө нь жижиг намуудаас үүдэлтэй юу эсвэл эсрэгээрээ юу, магадгүй харилцан үйлчлэх зэрэгцээ нөлөө байгаа эсэхийг хэлэх боломжгүй. Эдгээр асуултыг нэлээд гүнзгийрүүлж судлах шаардлагатай.

Энэ үр дүн нь сонгуулийн тогтолцооны мажоритар бүрэлдэхүүнд анхаарлыг чиглүүлж байна. Мажоритар болон хувь тэнцүүлэх зарчмаар хуваарилах суудлын харьцааг 47/29, эсвэл 38/38 гэж хуваахад ихэнх аймагт хоёр мандат ногдох боломжтой. Тиймээс харьцангуй олонхын тогтолцооны хоёр мандат байх уу эсхүл багц саналын хоёр мандат байх уу гэдэг сонголт үүснэ. Загварчлалуудад 2020 оны УИХ-ын сонгуулийн багц саналын болон 2012 оны сонгуулийн мажоритар хувилбарыг ихэвчлэн хэрэглэсэн болно.

Намд үнэнч буюу тодорхой намыг тууштай дэмжих хандлага өндөртэй газруудад багц саналын систем

том намд ашигтай. Тийм биш газарт сонгогч мандатын тоогоор санал өгөхдөө бие даагчид, жижиг намыг төлөөлсөн, тухайн орон нутагт хүчтэй хувь нэр дэвшигчдийг дэмжих тал байж болохыг багц саналын системийг сонгоход бодолцож үзэх нь зүйтэй. Энэ нь намын жагсаалт хаалттай ба нээлттэй байх эсэх болон харьцангуй олонхын тогтолцоо ба багц саналын тогтолцооны нөлөөнд намын институтчлэгдэх байдал, түүнээс үүдэлтэй сонгогчид тодорхой намыг тууштай дэмжих хандлага өөрчлөгдөж болох тул цаг хугацаа өнгөрөхийн хэрээр дахин авч үзэж байх асуудал юм.

Суудал хуваарилахад оролцох саналын босго

- 2016, 2020 оны УИХ-ын сонгуулиудад улсын хэмжээнд таван хувь хүртэл санал авсан жижиг нам байхгүй байна. Энэ нь саналын босго байсан ч шууд үзүүлэх нөлөө нь бага гэсэн үг юм.

Хэрэв улсаараа 29 мандаттай нэг том тойрог болох нөхцөлд *Hare* ХИҮ механизмыг ашиглавал квот нь $1/29=3.45$ хувь болно. Ийм хэмжээний дэмжлэгтэй нам суудал баттай авах бөгөөд чансаа нь ойролцоогоор хоёр хувь хүрэхгүй ч суудал авах боломжтой, харин нэг хувь хүрэхгүй үед суудал авах магадлал нь багасна.

Гадаадад санал өгөх

- Гадаадад оршин суугаа сонгогчдоос холимог тогтолцоогоор санал авах тохиолдолд зохион байгуулалт, санхүүгийн нөөц боломж сонгуулийн тухайн тогтолцоонд шаардагдах түвшинд хангалттай хүрэлцээтэй эсэхэд үнэлгээ хийх шаардлагатай. Дэлхий даяар гадаадад санал хураалтыг хэрхэн зохион байгуулдаг талаарх АСДҮОУХ байгууллагаас гаргасан [“Гадаадаас сонгуульд санал өгөх нь”](#), [“Гадаадад санал өгөх талаар: Туршлагаас суралцахуй”](#), [“Гадаадад санал өгөх талаарх мэдээллийн сан”](#) зэрэг эмхэтгэлийг үзэж болно.

Тэнцвэргүй хуваарилалт

- Өмнөх туршлагаас үзэхэд мандатад ногдох сонгогчдын хуваарилалтын тэнцвэргүй байдал Монгол Улсын сонгуулийн системд байсаар ирсэн ба хуулиар үүнийг зохицуулаагүй байна. 2020 оны УИХ-ын сонгуулиар нэг мандатад Улаанбаатар хотод 37,266 сонгогч, бусад

газарт 21,274 сонгогч ногдож байсан. Үүний үр дагавар нь Улаанбаатар хотод бага хувиар санал авах намуудад ашигтай, харин Улаанбаатар хотод ахиу хувиар санал авах намуудад хохиролтой. Харин Улаанбаатарт болон бусад газарт ижил хувиар дэмжлэг авдаг намуудад төдийлөн нөлөө үзүүлэхгүй. Мандатын тэнцвэргүй хуваарилалтын асуудлыг шийдвэрлэхийн тулд сонгуулийн тойргуудын хилийн заагийг өөрөөр тогтоох арга замын талаар *International IDEA Electoral Redistricting App (ERA)* хэмээх хамгийн сүүлийн үеийн хэрэгслийг ашиглах боломжтой.).

ҮНДСЭН ХУУЛЬД СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААР ЗААСАН НЬ

Сонгуулийн шинэ тогтолцоог хэрэгжүүлэхэд холбогдох заалтууд бүхий эрх зүйн баримт бичгийг батлах шаардлагатай. Тэгэхээр Үндсэн хуульд болон Сонгуулийн тухай хууль, дагалдан гарах журмаар юуг зохицуулах вэ? гэдэг асуулт гарна.

Дэлхий даяар сонгуулиар эмхлэн байгуулах хууль тогтоох байгууллага болон түүний суудлын тоог үндсэн хуульдаа заасан байдаг. Харин ихэнх улс сонгуулийн тогтолцоог тусгай хуулиар буюу сонгуулийн хуулиар зохицуулах тухай шаардлагыг заалт болгон оруулсан байдаг аж.

Сонгуулийн тогтолцоог үндсэн хуульд заах нь ялимгүй өөрчлөлт оруулахаас эхлээд ялангуяа улс төрийн өөрчлөлт, шилжилтийн үе шатанд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болоход ихээхэн хүндрэл бэрхшээл үүсгэдэг гэж үзэх нь нийтлэг байдаг. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг үнэмлэхүй олонхын саналаар батлах гэхчлэн өндөр босго тавих нь дурдсан бэрхшээл үүсэхэд нөлөөлдөг. Үндсэн хуулийн зохицуулалтаас үүдсэн яриа хэлэлцээ, зөвшилцөл зохицолд хүрэх улс төрийн үйл явц түүнээс илүү хүндрэл үүсгэдэг. Нэмэлт өөрчлөлт оруулахын ашиг тусыг ойлгосон талууд хүртэл үндсэн хуулийн хэлэлцүүлгийг эхлүүлэхэд сонгуулийн тогтолцоонд холбогдолгүй үндсэн хуулийн бусад амаргүй асуудлаар нэгэнт бий болсон хэлцлийг унагаах эрсдэлээс болгоомжилдог.

Гэвч Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог нарийвчлан заасан цөөн жишээ зарим улс оронд байна. Тухайлбал, Мексик Улс холимог параллель, Нигери Улс харьцангуй олонхын тогтолцоог, Филиппин Улс харьцангуй олонхын

тогтолцооны гол элементийг авсан холимог параллель тогтолцоог үндсэн хуульдаа заасан байдаг. Гүрж Улсын үндсэн хуульд тус улс нутаг дэвсгэрээ бүрэн хянадаг болтол нэг тойрог бүхий хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгох нэг танхимтай хууль тогтоох байгууллагатай байна гэж заасан. Тэр цаг ирэхэд хууль тогтоох байгууллага нь хоёр танхимтай болж, сонгуулийн тогтолцоо нь хувь тэнцүүлсэн хэвээр байх боловч олон мандаттай нэг тойрогтой байна гэдэг заалт үгүй болсон байна.

Үндсэн хуульд сонгуулийн тогтолцооны ерөнхий хэлбэрийг зааж, бусад нарийвчилсан зохицуулалтыг хууль тогтоомжийн хүрээнд шийдэх хувилбарыг авч үзүүштэй. Үүнийг Гүрж Улсын урт хугацааны заалтаас гадна Польш, Өмнөд Африкийн жишээнээс ч харж болно.

ХУРААНГУЙ

- Сонгуулийн тогтолцооны аль хувилбарыг авах вэ? гэдэг хэлэлцүүлэг бол үндсэндээ юуг чухалчлан **тэргүүн ээлжид тавих тухай асуудал юм**. Олонх/дийлэнхийн болон хувь тэнцүүлэх тогтолцооны давуу талуудыг нэгтгэсэн холимог сонгуулийн тогтолцоо нь сонгуулийн системүүд дунд нэлээд түгээмэл танигдсан хувилбар юм.
- **Нарийвчилсан зохицуулалтууд юу юунаас чухал болохыг** таньж мэдсэний үндсэн дээр боловсруулсан сонгуулийн тогтолцоо бол хамгийн шилдэг нь юм. Тогтолцоо хэрхэн хэрэгжихийг хангалттай түвшинд тодорхой заагаагүйгээс сонгуулийн маргаан үүсэх нөхцөл бий болох ба энэ нь сонгуулийн хууль ёсны гэж хүлээн зөвшөөрөгдөх байдалд хохирол учруулдаг. Асуудлыг тодорхой зохицуулалгүй орхисноос маргалдагч талууд өөр өөрийнхөөр ойлгож тайлбарлах байдалд хүргэх нь зохисгүй юм.
- **Сонгуулийн тогтолцоог тодорхой байлгахын тулд Үндсэн хуульд ерөнхий байдлаар заадаг нь оновчтой** туршлага бөгөөд нарийвчлан тусгах нь хүсүүштэй зүйл биш. Нарийвчилсан зохицуулалтыг сонгуулийн хуульд тусгах боломжтой ба хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг сонгуулийн асуудлаарх эрх бүхий этгээд гаргахаар тодорхой зааж зохицуулах боломжтой.
- **Хувь тэнцүүлсэн холимог, параллель гэх мэт аль нэг холимог сонгуулийн тогтолцоог нэгэнт сонгосон**

нөхцөлд бусад олон асуудлыг шийдвэрлэх шаардлага бий болно. Эдгээрийн зарим нь сонгуулийн тогтолцоог тодорхойлох процесст хамаарна. Үүнд, намын жагсаалтын болон мажоритар суудлын харьцаа, хувь тэнцүүлэх бүрэлдэхүүний саналыг тооцох аргачлал буюу тооллогын механизм, хаалттай болон нээлттэй жагсаалт болон саналын босго зэрэг асуудал багтана. Бусад асуудал нь тогтолцооны бүтцээс гаднах буюу тогтолцооны хоёр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд санал хураалтыг зохион байгуулж сонгуулийг удирдан явуулах бүтэц, гадаадад санал хураах гэх мэт байна.

- Сонгуулийн тогтолцооны хэлбэрийн хувьд туйлын зөв хариулт гэж үгүй. Нэг нөхцөлд тохиромжтой байсан тогтолцоо нөгөө нөхцөлд өөр байх бололцоотой. Нэг газрын сонгуулийн тогтолцоог нөгөө газарт ижил үйлчилнэ гэж бодоод шууд хуулж хэрэглэх гэвэл ухаалаг хэрэг биш болно.
- Тэргүүлэх зорилтыг хэрхэн тодорхойлсон, сонгуулийн ямар тогтолцоог сонгосноос үл хамаарч сонгуулийг удирдах байгууллага, сонгуульд оролцогч талууд хоорондоо **ямагт нээлттэй, харилцаа холбоотой байж, хэлэлцэж ярилцан иргэний болон сонгогчдын боловсролд тууштай анхаарах нь нэн чухал.**

ХАВСРАЛТ 1. ХОЛИМОГ СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО: ЖИШЭЭ, ЭХ СУРВАЛЖ

Холимог тогтолцооны нэг төрөл: Параллель

- Параллель систем хоёр өөр, салангид бүрэлдэхүүн хэсэгтэй.
- Парламентын суудлын заримыг дийлэнх/олонхын, заримыг хувь тэнцүүлэх зарчмаар хуваарилна.
- Нэр дэвшигч болон намыг төлөөлөх нэр дэвшигчийг сонгох саналын нэг хуудас эсхүл тойрогт нэр дэвшигчид болон намыг сонгох хоёр саналын хуудас байж болно.

Параллель тогтолцооны жишээ (1)

	Тойргоос сонгогдох гишүүд	Саналын хувь	Жагсаалтаар сонгогдох гишүүд	Парламентын нийт гишүүн
A нам	24	40%		
B нам	6	16%		
C нам	10	24%		
D нам	20	20%		
Нийт	60	100%		100

Параллель тогтолцооны жишээ (2)

	Тойргоос сонгогдох гишүүд	Саналын хувь	Жагсаалтаар сонгогдох гишүүд	Парламентын нийт гишүүн
A нам	24	40%	16	
B нам	6	15%	6	
C нам	10	25%	10	
D нам	20	20%	8	
Нийт	60	100%	40	100

Параллель тогтолцооны жишээ (3)

	Тойргоос сонгогдох гишүүд	Саналын хувь	Жагсаалтаар сонгогдох гишүүд	Парламентын нийт гишүүн
A нам	24	40%	16	40
B нам	6	15%	6	12
C нам	10	25%	10	20
D нам	20	20%	8	28
Нийт	30	100%	20	100

Холимог тогтолцооны өөр нэг хувилбар: Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо

- Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо (ХХТТ) нь харилцан хамаарал бүхий хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй
